



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/010-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026 03. 25 № 173
танай _____ -ны № _____ -т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.ГАНЗОРИГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Архангай аймгийн Эрдэнэбулган сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын төсвийн 17 нэр төрлийн орлогоор 11,924.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 13,579.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөө нийт дүнгээр 113.9 хувиар давж биелжээ.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 7 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 9,226,818.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 8,272,923.7 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 953,894.4 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Засаг дарга нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 83.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,377,827.75	3,762,183.56
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,435,257.12	2,766,213.1
3	АВЛАГА	790,950.34	878,896.26
4	БАРАА МАТЕРИАЛ	132,930.3	54,548.9
5	НӨӨЦИЙН БАРАА	18,690	62,525.3
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,908,161.48	3,180,314.2
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,908,161.48	3,180,314.2
8	Биет хөрөнгө	15,819,047.98	2,720,060.2
9	Биет бус хөрөнгө	89,113.5	460,254
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,285,989.23	6,942,497.76
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	217,589.12
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	217,589.12
13	Өглөг	0.0	217,589.12
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,285,989.23	6,724,908.64
15	Засгийн газрын хувь оролцоо	20,285,989.23	6,724,908.64
16	Засгийн газрын оруулсан капитал	2,590,312.78	2,590,312.78
17	Хуримтлагдсан үр дүн	17,666,586.67	4,105,506.08
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,089.79	29,089.79
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,285,989.23	6,942,497.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	14,857,396.65	14,866,429.8
2	ТАТВАРЫН ОРЛОГО	12,756,998.18	13,164,721.37
3	Орлогын албан татвар	11,710,458.71	12,310,137.11
4	Хувь хүний орлогын албан татвар	11,705,910.31	12,988,446.56
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-684,339.13
6	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	4,548.4	6,029.68
7	Хөрөнгийн албан татвар	600,901.16	523,808.65
8	Бусад татвар, төлбөр, хураамж	445,638.32	330,775.61
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,435,962.45	1,701,708.43
10	Тусламжийн орлого	0.0	5,832.23
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	664,436.02	0.0
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,794,490.79	13,611,783.31
13	УРСГАЛ ЗАРДАЛ	12,584,005.89	13,040,050.67

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,011,857.75	6,270,566.12
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,420,624.78	1,806,185.67
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	298,717.11	227,570.68
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,187,661.42	3,311,472.44
18	Хангамж, бараа материалын зардал	55,666.63	49,997
19	Нормативт зардал	9,600	0.0
20	Эд хогшил, урсгал засварын зардал	600,536.43	281,489.27
21	Томилолт, зочны зардал	8,030	5,660
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,191.95	69,157.7
23	Бараа үйлчилгээний бусад зардал	2,303,829.44	519,033.37
24	ТАТААС	0.0	148,000
25	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,572,148.13	6,621,484.55
26	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	210,484.9	571,732.64
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,062,905.86	1,254,646.49
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	709,533.9	14,815,727.08
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-709,533.9	-14,815,727.08
30	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,353,371.96	-13,561,080.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	14,073,755.27	14,171,763.42
2	ТАТВАРЫН ОРЛОГО	12,756,998.18	13,164,721.37
3	Орлогын албан татвар	11,710,458.71	12,310,137.11
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-684,339.13
5	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	4,548.4	6,029.68
6	Хөрөнгийн албан татвар	600,901.16	523,808.65
7	Бусад татвар, төлбөр, хураамж	445,638.32	330,775.61
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	350,447.39	301,021.04
9	Газрын төлбөр	95,190.92	29,754.57
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	652,321.07	1,007,042.05
11	Нийтлэг татварын бус орлого	652,321.07	573,315.75
12	Тусламжийн орлого	0.0	33,531.73
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	400,194.57
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	664,436.02	0.0
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,190,612.48	12,641,131.05
16	УРСГАЛ ЗАРДАЛ	11,190,612.48	12,641,131.05
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,618,464.34	5,871,246.5
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,421,424.23	1,805,785.67
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	298,717.11	227,570.68
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,183,633.42	3,171,511.57

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	Хангамж, бараа материалын зардал	46,108.01	48,135.8
22	Нормативт зардал	10,960	0.0
23	Эд хогшил, урсгал засварын зардал	569,757.34	229,513.6
24	Томилолт, зочны зардал	8,030	5,660
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,180.95	70,112.2
26	Бараа үйлчилгээний бусад зардал	952,653.29	312,956.98
27	ТАТААС	0.0	148,000
28	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,572,148.13	6,621,884.55
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,883,142.79	1,530,632.37
30	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	943,565.26	1,965,676.39
31	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	943,565.26	1,965,676.39
32	Дотоод эх үүсвэрээр	943,565.26	1,965,676.39
33	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-943,565.26	-1,965,676.39
34	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	234,000
35	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-234,000
36	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,939,577.53	-669,044.02
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,495,679.59	3,435,257.12
38	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,435,257.12	2,766,213.1

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,932,617.27	18,932,617.27
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,932,617.27	18,932,617.27
3	Тайлант үеийн үр дүн	1,353,371.96	1,353,371.96
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,285,989.23	20,285,989.23
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,285,989.23	20,285,989.23
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,285,989.23	20,285,989.23
7	Тайлант үеийн үр дүн	-13,561,080.59	-13,561,080.59
8	1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,724,908.64	6,724,908.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөөнийг устгалын дараах	Гүйцэтгэлийн устгалын дараах	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,371,131.60	13,738,037.12	1,366,905.52	111.05
11	Татварын орлого	11,784,254.60	13,164,721.37	1,380,466.77	111.71
110	Орлогын албан татвар	10,761,911.50	12,310,137.11	1,548,225.61	114.39

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1100	Хувь хүний орлогын албан татвар	11,454,255.50	12,988,446.56	1,534,191.06	113.39
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	9,729,400.00	10,644,265.00	914,865.00	109.40
110002	Үйл ажиллагааны орлого	247,865.50	294,893.12	47,027.62	118.97
110003	Хөрөнгийн орлого	1,168,900.00	1,466,965.39	298,065.39	125.50
110004	Хөрөнгө борлуулсны орлого	294,820.00	487,827.85	193,007.85	165.47
110008	Шууд бус орлого	13,270.00	94,495.20	81,225.20	712.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(700,000.00)	(684,339.13)	15,660.87	97.76
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(700,000.00)	(684,339.13)	15,660.87	97.76
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	7,656.00	6,029.68	(1,626.32)	78.76
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	7,656.00	6,029.68	(1,626.32)	78.76
113	Хөрөнгийн албан татвар	645,923.70	523,808.65	(122,115.05)	81.09
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	570,383.70	429,911.95	(140,471.75)	75.37
113002	Бууны албан татвар	8,340.00	9,810.00	1,470.00	117.63
113004	Малд ногдуулах албан татвар	67,200.00	84,086.70	16,886.70	125.13
118	Бусад татвар, төлбөр, хураамж	376,419.40	330,775.61	(45,643.79)	87.87
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	329,668.90	301,021.04	(28,647.86)	91.31
118001	Улсын тэмдэгтийн хураамж	6,250.00	12,593.84	6,343.84	201.50
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	7,177.50	9,406.52	2,229.02	131.06
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	316,241.40	279,020.67	(37,220.73)	88.23
1181	Газрын төлбөр	46,750.50	29,754.57	(16,995.93)	63.65
118101	Газрын төлбөр	41,750.50	29,754.57	(11,995.93)	71.27
118102	Дуудлага худалдаа	5,000.00	-	(5,000.00)	-
12	Татварын бус орлого	586,877.00	573,315.75	(13,561.25)	97.69
120	Нийтлэг татварын бус орлого	586,877.00	573,315.75	(13,561.25)	97.69
120003	Торгуулийн орлого	100,000.00	351,529.64	251,529.64	351.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	481,877.00	212,581.11	(269,295.89)	44.12
120009	Бусад орлого	5,000.00	9,205.00	4,205.00	184.10
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,226,818.10	8,272,923.70	(953,894.40)	89.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,554,348.60	6,094,646.32	(459,702.28)	92.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,072,870.50	5,631,543.09	(441,327.41)	92.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,870,730.10	1,805,785.67	(64,944.43)	96.53
210101	Үндсэн цалин	860,713.80	795,225.64	(65,488.16)	92.39
210102	Нэмэгдэл	780,313.80	774,059.81	(6,253.99)	99.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	150,720.10	128,842.04	(21,878.06)	85.48
210104	Урамшуулал	78,982.40	107,658.17	28,675.77	136.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,698.10	227,570.68	(6,127.42)	97.38
210201	Тэтгэврийн даатгал	158,914.70	155,095.73	(3,818.97)	97.60
210202	Тэтгэмжийн даатгал	18,695.90	18,220.18	(475.72)	97.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,347.90	9,944.93	597.03	106.39
210204	Ажилгүйдлийн даатгал	9,347.90	8,902.99	(444.91)	95.24

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	37,391.70	35,406.86	(1,984.84)	94.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,451,097.30	3,171,511.57	(279,585.73)	91.90
210301	Гэрэл, цахилгаан	481,844.20	366,125.96	(115,718.24)	75.98
210302	Түлш, халаалт	2,451,145.90	2,426,918.30	(24,227.60)	99.01
210303	Цэвэр, бохир ус	518,107.20	378,467.31	(139,639.89)	73.05
2104	Хангамж, бараа материалын зардал	56,500.00	45,616.96	(10,883.04)	80.74
210401	Бичиг хэрэг	18,000.00	14,304.10	(3,695.90)	79.47
210402	Тээвэр, шатахуун	13,000.00	11,871.13	(1,128.87)	91.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,000.00	12,476.47	(3,523.53)	77.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,500.00	6,965.26	(2,534.74)	73.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	258,427.80	250,912.60	(7,515.20)	97.09
210602	Тавилга	25,000.00	21,399.00	(3,601.00)	85.60
210604	Урсгал засвар	233,427.80	229,513.60	(3,914.20)	98.32
2107	Томилолт, зочны зардал	8,000.00	5,660.00	(2,340.00)	70.75
210702	Дотоод албан томилолт	8,000.00	5,660.00	(2,340.00)	70.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,675.30	66,798.81	(22,876.49)	74.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,325.30	63,968.68	(22,356.62)	74.10
210803	Даатгалын үйлчилгээ	1,000.00	795.41	(204.59)	79.54
210804	Тээврийн хэрэгслийн татвар	700.00	558.75	(141.25)	79.82
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	650.00	514.44	(135.56)	79.14
210807	Газрын төлбөр	1,000.00	961.53	(38.47)	96.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	338,440.00	285,257.48	(53,182.52)	84.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	295,000.00	276,067.48	(18,932.52)	93.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	43,440.00	9,190.00	(34,250.00)	21.16
212	ТАТААС	148,000.00	148,000.00	-	100.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	148,000.00	148,000.00	-	100.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	148,000.00	148,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,780.00	87,532.55	(12,247.45)	87.73
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,000.00	27,000.00	-	100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	27,000.00	27,000.00	-	100.00
213103	Төсвийн санхүүжилт	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,780.00	60,532.55	(12,247.45)	83.17
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,780.00	12,780.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,046.00	25,046.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,954.00	22,706.55	(12,247.45)	64.96
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,232,469.50	1,944,277.39	(288,192.12)	87.09
222001	Тоног төхөөрөмж	1,336,727.00	1,102,885.51	(233,841.49)	82.51
223001	Бусад хөрөнгө	895,742.50	841,391.88	(54,350.63)	93.93
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	440,000.00	234,000.00	(206,000.00)	53.18
230001	Эргэж төлөгдөх зээл	440,000.00	234,000.00	(206,000.00)	53.18
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,378,011.60	5,692,684.10	2,314,672.50	168.52

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(3,378,011.60)	(5,692,684.10)	(2,314,672.50)	168.52
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(3,378,011.60)	(5,692,684.10)	(2,314,672.50)	168.52
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,435,257.12	3,435,257.12	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,766,213.10	2,766,213.10	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	55.00	48.00	(7.00)	87.27
620001	Удирдах ажилтан	5.00	4.00	(1.00)	80.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	33.00	(4.00)	89.19
620003	Үйлчлэх ажилтан	13.00	11.00	(2.00)	84.62
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55.00	48.00	(7.00)	87.27
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	27.00	23.00	(4.00)	85.19
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	15.00	(3.00)	83.33
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	10.00	10.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	33,531.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,531.73
122	Тусламжийн орлого	33,531.73
1221	Хандив тусламж /дотоод/	33,531.73
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,531.73
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,832.23
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,699.50
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,531.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,531.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,531.73
2104	Хангамж, бараа материалын зардал	2,518.84
210402	Тээвэр, шатахуун	2,308.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,313.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,313.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,699.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,699.50

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй. Харин залруулагдаагүй нийт 50,842.9 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 1 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 24,093.0 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг материаллаг гэж үнэлсэн. Мөн төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 50,842.9 мянган төгрөгийн, нийт 74,935.9 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын дүн **92,268.2** мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Орон нутгийн орлогыг хянахад хог хаягдлын хураамжийн орлогыг 37,220.7 мянган төгрөгөөр, газрын төлбөрийг 11,995.9 мянган төгрөг, орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй орлогын албан татварыг 1,626.3 мянган төгрөг, нийт 50,842.9 мянган төгрөгөөр орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хотын төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг бодитой төлөвлөн, орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэн ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
												/мянган төгрөгөөр/	
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Орлого	1	50842.9			1	50842.9							
Нийт дүн	1	50842.9			1	50842.9							

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	1	1122.8			1	1122.8						
ЗДТГ	4	22970.5	1	953.2	3	22017.3						
Орлого	1	50842.9			1	50842.9						
Нийт дүн	6	74936.2	1	953.2	5	73983.0						